



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/229

Арвайхээр


Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын инженерийн шугам, сүлжээ бүхий газарт Эрдэнэт булганы цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн Өвөрхангай аймаг дахь салбарт 1 дүгээр багийн 2 дугаар гудамжны зүүн талд байрлах АТП-405 дэд станцын зориулалттай 100м<sup>2</sup> газар, 5 дугаар багийн Гэндэнгийн гудамжны 204 тоотын баруун талд байрлах КТП-394 дэд станцын зориулалттай 11м<sup>2</sup> газрыг тус тус эзэмшүүлсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрх авсан хуулийн этгээдтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100501